

**С. БУЯННЭМЭХИЙН ДАЛД АМЬДРАЛ БОЛООД
ДАЛД УТГАТ НЭГЭН ТУУЖИЙН ТУХАЙД**

Д. Цэнджав *

Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч, ууган зохиолч Сономбалжирын Буяннэмэхийн амьдрал бүр бага балчираасаа жаргалтай сайхан байсангүй, хэн хүнд тохиолдохооргүй хүнд бэрх зовлонг туулж иржээ. Тэрбээр одоогийн Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг “Булгийн хүрэн хошуу” гэдэг газар төржээ. Түүнийг цахар, өвөрлөгч гэж андуурч будилж байсан ч гэлээ яахын аргагүй “мухар хуруу” Сономбалжир гэгчийн үр хүүхэд болохыг тогтоосон байна. Одоо ч гэсэн аавынх нь болон ээжийнх нь талын ахан дүүс улам өнөр өтгөн болжээ. Буяннэмэхийн аавынх нь дүү Адьяадоржийн Лувсандашийн хүүхдүүд, ахан дүүс олон байна. Жараад оны дундуур Мандалговь хотын арван жилийн сургуульд Лувсандаш гэгч гялалзсан хар нүдтэй, бэлэн зэлэн үнэн үгтэй, нэлээд шударга шулуун зантай байрын Лувсандаш гэдэг газар зүйн багш бидэнд хичээл заадаг байлаа. Их л өргөн мэдлэгтэй хүн байсан. Сүүлд сонсохноо, үр хүүхдүүддээ “*Та нар гэртээ номын сангүй бол би хэзээ ч очиж байхгүй шүү*” гэсэн хатуу шаарддаг байсан тухай өнөөгөөр Дархан хотын ерөнхий шүүгч хүү Л.Амарсанаа надад хууч хөөрсөн юм. Ном, соёлын асар их өв уламжлалтай тэрбээр өөрөө монголын бараг бүх романыг уншсан байх юм. Лууяа багшийн охин Амгалан одоо ч нийслэлийн Баянгол дүүргийн засаг даргын албыг амжилттай хаасан, төрийн нэлээд сайнд тооцогдохоор эмэгтэй удирдагч болжээ. Ээжийн талын ахан дүүс болох хүүхдийн зохиолч Цогтсугир “*Алтан өд*” шилдэг бүтээлийн шагнал хүртсэн шаггүй авъяастан бололтой. Буяннэмэхийн хүргэн Ц.Цэдэв 1966 онд Москвад монголын элчин сайдын яаманд худалдааны төлөөлөгчийн ажилтан байхдаа “*Мосфильмийн*” бүтээл “*Онгоцны үйлчлэгч эмэгтэй*” гэдэг уран сайхны кинонд чукотк өвгөнийн дүрийг амжилттай бүтээжээ. Орос кинонд тоглосон анхны хүн учраас бас л авъяас билгийн очтой урлагийн хүн байж таарах гээд байна. Цэрэнжавын Цэдэв гуайг эсэргүүний хүргэн гэдгээр хэрэгтэн болгон байцааж 10 жилийн ял сонсож, шоронгийн бэрх амьдралыг туулсан нэгэн байв.

Хар нялхдаа өнчирсэн учир холын говь нутгаас Хүрээнд амьдарч байсан нагац эгч Чимэдийн асрамжинд арай гэж амь голтой хүргэгдэж ирсэн аж. Амьдрал ядуу зүдүү, хүний өөрийн хүүхдийг өсгөх хэцүү байсан тул түүний нөхөр цахар Лувсан нутаг усны болоод эр хүний түшиг болсон Тогтох тайжийнд үрчлүүлжээ. Тэр үед өвөрлөгч болоод хүрээнд хэд хэдэн Тогтох гэсэн хүний нэр дуулддаг юм. Түүнийг үрчилж авсан энэхүү Тогтох тайжийг арай өөр хүн болов уу? Д.Намдаг гуай андуураад хэлчихээгүй байгаа гэж миний бие эргэлзэж явсан ч гучаад оны утга зохиол болоод гол

* МУИС-ийн МХСС-ийн багш, доктор, дэд профессор

гол төлөөлөгчдийн амьдрал уран бүтээлийг ултай даацтай судалсан “С. Буяннэмэх судлал”-ыг тууштай хөгжүүлж дөрвөн боть ном зохиолыг гаргасан өвөр монголын профессор Ван Мандугай “Тэр болбоос Өвөр монголын Жирмийн чуулганы Горлос хошууны уугуул нөгөө эрэлхэг зоригт Тогтох тайж гарцаагүй мөн” гэж хэлснээр миний эргэлзээ тайлагдсан. Зоригт баатар Тогтох болбоос өвөр монголын эрх чөлөөний төлөө цогтой тэмцэгч, манж хятадуудтай зуу гаруй удаа тулалдаж эрслэн тэмцсэн, ялж ялагдаж явсан баатар зоригт түүхт хүн гэдгийг андахгүй бизээ. Түүний баатар эр зоригийг нутгийнхан шагшиж,

“Тоо Наан голын жараахайг

Тогоруу түүгээд барлаа

Тоо Тун нуугийн цэргийг

Тогтох алаад барлаа” гэж хүртэл дуу гарч байсныг 1932 онд шоронд

С.Буяннэмэхтэй цуг хоригдож, улмаар андууд гэж бололцсон зохиолч Донровын Намдаг “Шинэ Монголын шинэ театр” дурсамж номондоо тэмдэглэж үлдээжээ. Бас Намдаг гуайд “Тогтохынд анх ирж байснаа тун муу зүүд шиг мэддэг” гэж С.Буяннэмэх хэлж байсан нь яахын аргагүй баатар Тогтох үрчилж авсныг давхар баталж байгаа юм. Тэднийд 9 жил амьдарчээ. Автономит засгийн үед Тогтох тайж өвөрлөгч олон цэрэгтэйгээ халхад ирж суурьшихад Богд хаан ихэд талархан баярлаж угтсан төдийгүй цол хэргэм шагнасан баримт түүхэнд байдаг. Тэр ар монголынхонтой хүж барилцан ахан дүүгийн барилдлага тогтоохыг хүссэн нь балчир бага, ирээдүйн их бичгийн хүн С. Буяннэмэх санамсаргүй тааралдсан нь аз эзийг дагуулжээ. Зоригтбаатар Тогтохын дээл, малгай амьдралын туршид дайн дажны дарь утаанд үнэр нь гараагүй ч, бас чиг бичиг номыг дээдэлдэг бийр муутуу нийлүүлдэг язгуурын боловсролтой нэгэн байсан гурван хүүгийн нэгэн адилаар С.Буяннэмэхэд тухайн үедээ номтой гэгдсэн харчин Ашинга, өвөр монголын Эрдэнээр монгол бичиг, манж хэл, хятад хэлийг заалгажээ. Орос хэлийг ч хожмоо сурсан байна. Түүний хүү үеийн Эрхэмбаяр гэгчтэй нэлээд нөхөрлөж дотносож өссөн бололтой. Гэвч тэр олон дайнд эмнэгшиж догширсон баатар эр тул үр хүүхдүүд болоод бага балчир С.Буяннэмэхийг ширүүн гараар захирч, хүмүүжүүлж бас л багаасаа хатаагдсан байна. Энэ тухайд С.Буяннэмэх 1932 оны арваннэгдүгээр сарын 18-ны өдөр Намын Төв Хороонд бичсэн захидалдаа “...Өчүүхэн би бол Өмнөговь аймгийн (одоогийн засаг захиргаагаар Дундговь аймаг. До.Ц) халхын нэгэн ядуу малчин ардын хөвүүн бөгөөд хараахан багаас Тогтох тайжийн хөвүүдийн албат боол болж 17, 18 хүрч ухаан сэхээ орсноос тэдний дарлалаас зугатан зайлж Ар Хиагтын газраа очоод байх тэр үеэст чухамхуу бичиг мэдэхийн төдий бүдүүлэг ард байсан бөлгөө” гэж бичснээс үзэхэд багаасаа хатуу ажил, ширүүн гарт талхигдаж байсан нь мэдрэгдэж байна. Гэвч үүнийг хоёр талтай үзэх хэрэгтэй байх. Улсын түшээ гүн, сүжигт бэйс, Зоригт баатар Тогтохыг 1921 оны наадмын өмнөх өдөр баривчилж, Барон Унгерний цэрэгт тулалдаж явсан зэрэг хэд хэдэн ял хүнд тулгаж шоронд удтал эрүүдэн шүүж зовоосоор улмаар 1922 онд бусдад хорлогдсон байдалтай амиа алдсан байдаг. Иймээс ийм эсэргүүнд үрчлэгдэж явсныг үнэнээр өчвөөс хэлмэгдэх аюултай тул зориуд ийнхүү булзааруулсан байж болох. Бас Тогтохыг амь насаа алдснаас хойш түүний хөвгүүд яаж ч хандсан байж болох юм. “Өнчин хүний зовлон их, өртэй хүний шаналан их” гэгчээр түүний бага залуу нас тийм чиг жаргалтай, баяр хөөртэй, эрх дураараа сайн сайхан өнгөрсөнгүй.

С.Буяннэмэх ардын намын анхны тоотой хэдхэн гишүүний нэг төдийгүй монголдоо бараг мэргэжсэн хувьсгалч гэж болохыг хойно өгүүлье. 1921- 1924 онд

Эвлэлийн Төв орооны тэргүүлэгч гишүүн, дарга зэрэг хариуцлагатай ажлуудыг хийж явжээ. Энэ бол түүний амьдралын оргилуун боловч осол, аюултай үеийн нэг байлаа. Монголын залуучуудын эвлэл ардын намтай адилхан эрхтэй гэж арсалдаж ч байв. Намын гуравдугаар их хурал шиг хурц зөрчилтэй, хэрүүл тэмцэлтэй хурлыг манай түүх урд өмнө үзсэнгүй. Энэ нь нэг талд намын дарга бүх цэргийн жанжин Данзан нөгөө талд Элбэгдорж Ренчино нар ёстой хэн нь хэнийгээ вэ? гэж үзэлцэж байв. Энэхүү Элбэгдорж гэгч бол хувьсгалт үйл хэрэгт гол туслагч байсан бөгөөд 1921 онд намд элсэж цэргийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, эдийн засгийн зөвлөлийн гишүүн, НТХ-ын тэргүүлэгч гишүүн, улсын бага хурлын гишүүн зэрэг асар их эрх мэдэлтэй хүн байжээ. Энэхүү *"гишүүн"* гэгч үг өнөөдөр сул сонсогдож магад ч хэрэг дээрээ түүний үг бүхэн хууль болж байв. Аль аль нь тэр үеийн эвлэлийн дарга С.Буяннэмэхийг өөрийн талд татахын тулд бүхнийг хийж байлаа. Энэ хурлын үеэр залуучуудын эвлэлийн гишүүд *"Монгол интернационал"* дуулаад Гаалийн хорооны дэргэдэх талбайд индрийн хурал хийжээ. Энд хэлсэн С.Буяннэмэхийн үг үхэл ба амьдралыг зөгнөжээ. *"Тэрбээр ...Харгис этгээдүүд биднийг ямагт отож, аар саар өө сэв эрсээр байна. Үүнд хоёр намтай болж, хоорондоо муудаад, залуучуудын нам нь хөгшдийнхөө намыг устгах гэнэ. Залуу нам нь хөгшин намаа түлхэх гэнэ, хөгшин нам нь эвлэлээ устгах гэнэ гэх мэтийн цуу дэгдээж байна. Хуурамч явдал хорт цуурхал сөнөх болтугай"* гэж С.Буяннэмэхийг хэлэхэд, Данзан баяр хүргээд *"Эвлэл намд туслах хэрэгтэй бөгөөд хэрэв нам хазайхад хүрвэл эвлэл залруулж өгөх учиртай"* гэжээ. Эндээс л түүний цаашдын хувь заяаны чихийг чөтгөр маажиж эхэлсэн байна.

Ингээд л С.Буяннэмэх Данзантаны буюу баруунтны хамсаатан болж, ялж дийлсэн Элбэгдорж Ренчиногийн тавигдашгүй араа зуултанд оржээ. Ер нь ихээхэн эрх мэдлийг гартаа атгасан Ренчино гэгч бол хэрэг дээрээ намын болоод цэргийн эрхийг барьж байсан олон гэмгүй эх орончдыг цааш харуулахад онцгой үүрэг гүйцэтгэсэн этгээд юм. Жанжин Д.Сүхбаатарыг гэртээ өвчтэй хэвтэж байхад Ренчино ороод гарснаас хойш бие нь гэнэт муудсан гэж ерээд онд түүхч Бат-Очир гуай надад аминчилан хэлж билээ. Данзан, Баваасанг барин цаазалж, Буяннэмэх хомрогонд нь өртөж түүнийг шоронд нэг сар хорьсон байдаг юм. Эндээс амьдралаа дуусан дуустал хар дансанд бүртгүүлсэн түүний амьдын хар там эхэлжээ. Дараа нь эвлэлийн гуравдугаар хурлыг хийлгэж, Ренчинов *"С.Буяннэмэхийн өмнөх удирдлага ажиллагаа цөм буруу гээд улс төрийг үймүүлэх, нам эвлэлийг самууруулсан этгээд"* гэж шууд ял тулгасан нь ном эрдмийг чухалчилсан залуу С.Буяннэмэх балмагдан сэтгэл санааны маш хүчтэй цохилт авчээ. Оросын консулын нарийн бичгийн дарга Юдин *"Ренчино чамайг залуучуудыг залуучуудаар цохлуулах арга явуулах гэж байна"* гэж хэлсэн нь түүнийг буцашгүй алхам хийхэд хүргэсэн байна.

Ингээд С.Буяннэмэх Данзантны адил хувь заяа хар толгой дээр буусныг ойлгож харанхуй шөнөөр нийслэлээс нэгэн гайгүй морь олж аваад сэм гарч, Амгаланбаатарын зүг зүүн тийш оргож, элдэв адал явдлыг туулж явсаар Манжуур хотод хүрээд галт тэргээр Хөлөн Буйрын Хайлаар хотноо хуучин танил Буянгэрэлтэй уулзжээ. Ингэж Өвөрмонголын нутагт орж ирсэн байна. 24-хөн настай тэрбээр Коминтерний заавраар Өвөрмонголд хувьсгал хийхээр зориг шулуудсан нь түүнийг миний бие *"мэргэжлийн хувьсгалч"* гэж хэлж байгаа юм. Тэр олон дэвшилтэт сэхээтнүүдтэй уулзаж, шинэ цаг үе хувьсгалд уриалан дуудсан сэтгүүл гаргахаас ажлаа эхэлсэн. Харин түүнийг эх нутагт нь Данзантны хамаатан, эх орноосоо урван гарсан хэмээн эчнээгээр цаазын ял оноосон байв. Дотоод Монголын намын анхдугаар хурлыг зохион байгуулахад биечилэн

оролцож, шинэ байгуулагдсан Төв хорооны тэргүүлэгч болжээ. *“Дотоод Монголын ардын сэтгүүл”* удирдан гаргасан нь Дундад улсад цөөн тоот үндэстний үсэг бичгээр эв хамт ёсыг сурталчилан ухуулсан ууган хувьсгалт сэтгүүл болсон тухай хятадын хэвлэлийн түүхэнд тэмдэглэгджээ. Энэ сэтгүүл есөн дугаар гарч С.Буяннэмэхийг монгол руугаа буцахтай цуг хаагдаж зогссон байна.

1924 оноос хоёр жил энд байж, Бээжинд байгаа өвөр монголын оюутан сэхээтнүүдтэй холбоо тогтоохоор Бээжинд ирсэн үед Намын Төв Хорооны дарга Дамбадорж тааралдаад *“Бид чамайг хорьсон боловч Данзангийн хэрэгт ямар ч холбогдолгүй гэж тавьсан. Гэтэл чи алга болж орхив. Тэгтэл чи Өвөр монголд хувьсгалд оролцож яваа дуудлаа. Одоо буц. Ямар ч ял хэлцэхгүйг би Төв хорооны өмнө хариуцъя”* гэжээ.

Өвөр монголд ч бас түүний амьдрал түгшүүртэй байв. Данзан гэдэг аюулт дайсан гэгчтэй нэр холбогдсон С.Буяннэмэх бас нэгэн аюулт хүн Мэрсэйтэй нэр холбогдоод авсан нь хожим гай тарьж, 1932 онд дахин баривчлагдахын үндэс болжээ. Мэрсэй гэдэг нь С.Буяннэмэхийг Өвөр монголд ирэхэд дотночилон коминтернийн зөвлөгөөгөөр Өвөр монголд хувьсгал хийхээр хамтран ажиллаж байснаа гэнэт тангарагаасаа буцаж хятадын генерал Жан-Зо-Линд урвасан холионы этгээд юм. Мэрсэй түүний нэрийг хөөдөж, хожмын зовлон хэлмэгдлийг үүрэлцсэн гэхэд болно. Тэр байцаалт өгөхдөө *“Мэрсэй бол намайг байтугай коминтернийг мэхэлсэн хүн шүү дээ”* гэж учирласан байдаг. Түүнийг гоочлогсод *“Буяннэмэх МАН-ын эрмэлзэх 10 зүйлээр Өвөр монголд хувьсгал хийх гэж явсан хүн, Ленинтэй хүртэл сандал булаацалдсан гэл үү”* гэхчилэн ёжлон даапаалж байв.

Тэр гагцхүү монголынхоо дэвжээнд амь зуугаад байсангүй, өвөр монгол буриад гээд хоёр тийшээ гарч ажиллажээ. Хувьсгалын өмнө Эрхүү хотод коминтернийн төлөөлөгч Б.З. Шумяцкийн удирдлагаар *“Монгол үнэн”* сонинг анх гаргасан гавъяат хүн. Өвөр Монголын дараа Буриадад бас нэг жил болоод ирэхэд Улаанбаатар хотын дарга зэрэг томхон албан тушаалд дэвшүүлэн тавьж байсан ч амар тайван байсангүй. Дандаа хувьсгалт хэргээр, улс орныхоо төлөө зүтгэж байвч түүнийг байнга хяхан хавчиж, гадуурхаж, баруунтан хэмээн матаж байсан нь түүний идэвхтэй үйл ажиллагаатай холбоотой. Тэр улс төрийн янз бүрийн ажлаас татгалзаж цэвэр урлаг уран сайхны ажлыг дагнан хийхийг зорьж байв. Ерөнхий сайд А. Амарт *“...Миний бие аливаа албан үүргээс бүрмөсөн чөлөөлж ганцхүү өөрийн авъяас чадварт таацах утга зохиол, бичиг эрдмийг дэлгэрүүлэх тал дээр шуудран гарч нэгэнт биеийг боловсруулах ба хоёрдугаарт бичиг зохиол үйлдэж суухыг гагцхүү зорьж байна”* гэж бичиж байлаа. Энэ нь ирээдүйд энэ цаг төрд хэлмэгдлийн аюул нөмөрч байгааг зөнгөөрөө мэдэрч ойлгож байжээ. Үүнийг аюулт 1937 оны өмнөхөн бичсэн захидал юм.

Урансайхны улс төрийн зөвлөлийн дарга гэдэг чухамхуу одоогийнхоор бол Соёлын яам гэхээр яг таарсан ажилд томилогдож урлаг, утга зохиол, уран сайхны ажилд ханцуй шамлан оржээ. Буяннэмэх шиг утга зохиолыг хөгжүүлэхийн төлөө бүхий л авъяас билэг, хүч чадлаа дайчилж, залуу зохиолчдыг сурган хөгжүүлж, сургууль хичээл заадаг байсан талаараа түүний зиндаанд хүрэх сэхээтэн байхгүй. Энэ тухайд их зохиолч Дашдоржийн Нацагдоржоос ч давж гарсан гэхэд болно. Тэр үеийн бараг бүх зохиолчид түүний шавь, бишрэгч байсан юм. Ц.Дамдинсүрэн гуай *“Би түүнийг Улаанбаатар хотын намын хорооны дарга байхаас нь эхлээд олон жил танил байж, гэрээр нь байн байн очиж, уран зохиолын онол шүүмжлэлийг сонсож, түүнээс бага*

биш зүйлийг сурч авсан” гэж бичиж байлаа. Ер нь залуу зохиолчдод гэрээрээ багшилж, хэрхэн бичихийг зааж зурж байсан тухайд олон дурсамж байх юм. Тэрбээр,

“Өндөр дээрээс хүнгэнэн дуугарагч радио уран сайхан

Өөрийн үгийг өгүүлж болдог радио уран сайхан” гэж жаахан гуншаадуу, цахар аялгуугаар хуучирдан аялгуулж хэлдэг энэ үг тухайн үедээ олон хүний зүрхэнд хүрсэн хүн бүхний мэддэг сүлд шүлэг болж байжээ.

Урлаг уран сайхны ертөнцөд бас нэгэн дайсантай болсон нь тухайн үедээ жүжгийн зохиол бичих талаараа гаршиж нэрд гарсан гол өрсөлдөгч жүжиг судлаач Ши. Аюуш байлаа. С.Буяннэмэхийн бичсэн жүжгийг театрт тавиулахгүй, элдвээр хавчиж, тэр ч бүү хэл өөрийн мэдлийн жүжигчдээ радиогоор тоглуулахгүй хэмээн хясаж эсэн бусын хэл ам гаргаж байв. Зохиолчид цугларах театрын танхимаа хүртэл харамлан дайрч, элдэв яриа цуурхал тарааж, “Үнэн” сониноор бусдад захиалга өгөн бичүүлж, өөрийнхөө жүжгийн дал, наяд хувийг театрт тавьж бусад зохиолч нөхдийн бүтээлийг хавчиж байсан гэж дайрч байв. С.Буяннэмэхийг ирсэн замаараа сурсан дуугаа дуулаад буц гэж хүртэл дайрч байжээ. *“Энэ бол чи манай монголын харъяат биш”* гэсэнтэй утга нэг юм. Аль 1924 оноос Данзантаны хэргээр зүрхээ зүсүүлсэн С.Буяннэмэхийг дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болж тэр үеийн бүх удирдагч Амар, Гэндэн, Чойбалсан, Лосол, Лувсаншарав, Лувсандорж нар болон МАХН-ын төв хороо, төв хянан байцаах комисст өөрийгөө ойлгуулахын үүднээс захидал, өргөдөл, гомдол нэлээдийг бичсэн байна. Ерөөс 20 гаруйхан насандаа цаазын ял сонсож, дөрвөн удаа баригдаж, гурван удаа шоронд суусан хүний сэтгэл санаа ямар байх билээ.

Адгийн наад зах нь түүнийг үйлдвэрчний үүрээс гэнэт гишүүнээс хөөжээ. Шалтгаан нь хуралд ирдэггүй, даалгасныг гүйцэтгэдэггүй, татвараа өгдөггүй гэсэн аахар шаахар шалтгаанаас болжээ. Нийгмийн асар их идэвхтэй, дайчин хэлэмгий, жинхэнэ шилдэг зохион байгуулагч, эрдэм чадал арвин, олны дунд нэр нөлөө их нийгмийн зүтгэлтэн учраас Буяннэмэхгүй юм байсангүй, хувьсгалын болон намын их ой болсон ч тэр, наадам болсон ч тэр, соёл урлагийн томоохон концерт, үзэсгэлэн, жүжиг ший тавьсан ч тэрийг дайчилж байсан болохоор үйлдвэрчний эвлэлийн хуралд сууж завддаггүй байсан нь тодорхой. Тэр үеийн олон нийтийн байгууллага бие биетэйгээ өрсөлдөж, өөрсдийгөө аль нэг талаараа томд үзэж, нэр төр олохыг улайран хөөцөлдөж байжээ. Нэг томоохон байгууллагын гишүүнээс хөөгдөнө гэдэг бас л аюултай зүйл байлаа. Гучаад онд жаахан юмнаас болоод л толгой авахуулах нь ойрхон тул жижиг зүйл гэж байсангүй. Бас нэг айхтар хурцаар шүүмжлэгч, дайран довтлогч тухайн үед Багшийн сургуулийн багш байсан эхлэн бичигч Цэрэндоржийн Цэдэнжав юм. Тэр хурал болгон дээр хурцаар дайран давшлан шүүмжилж сэтгэлийн зовлон дээр зовлон нэмж байв. *“Уран сайхны улс төрийн зөвлөл хэмээх байгууллага улсын дотор явуулсан хэрэг ергүй хэмээгээд энэхүү газрын удирдлагад өвчин байна гэж дайрчээ. Түүний оройд суугаа (С. Буяннэмэхийг хэлж байна До.Ц) этгээд нь зохиолчдын зохиолуудыг дарж гагцхүү өөрийн алдраа их болгох гэсэн туйлын бузар буртаг бүхий этгээд болно”* гэж зүрх рүү нь чичлэн шүүмжилж байлаа. *“Бузар буртаг бүхий этгээд”* гэх хэллэг тэр үед ихээхэн газар авч байсан төдийгүй бууны гохонд хүргэж байсан юм. Тэрбээр өс хонзон санаж цөөнгүй зохиолчдыг ийм аргаар гутаан доромжилж байв.

“Нялуун хэлт Буяннэмэх

Нямбай харцат Аюуш

Хар хошуут Ядамсүрэн

Халдан долигногч Санжид...гэх буюу

*Гунишаагаар шүлгийг гутаасан Буяннэмэх
Хулгайгаар жүжсгийг эвдсэн Аюуш
Амраг янагийн зохиолыг хэтчилсэн Ядамсүрэн*

Армаг тармаг өгүүлэгээрээ амт таньсан Санжид” гэхчилэн утга учиргүй дайрал үгийг толгой холбон цувуулж гагц Буяннэмэхийг ч биш тэр үедээ манлайлж байсан олон нэрт зохиолчийн сэтгэлд доромжлолын сүүдрээ унагаж байжээ. Хардалт сэрдэлтийн шархан дээр давс цацсан тэрбээр ерээд оны эхээр мөн л гучаад оны хорлонт сэтгэлээр нэгэн нэрт зохиолчийг дайрсан шившгийн шүлгэрхүү юм нь цагаан цаасан дээр үлдсэнийг хэн хүнгүй мэднэ. Харин түүнээс бусад нь С.Буяннэмэхийг багшаа гэж хүндэлж тэр хэрээр монголын уран зохиолд Хөдөөгийн хэмээх Пэрлээ, Дондогийн Цэвэгмид зэрэг олон авъяастныг дэмжин гаргаж ирсэн төдийгүй, тэр үеийнхэн бараг бүхэлдээ түүний номын шавь нар байсныг түрүү дурдсан. Хэрвээ хэлмэгдэлийн шуурганд өртөөгүй бол Ц.Дамдинсүрэн, Б.Ринчений зиндааны магад зарим талаар давж гарсан ч байж магадгүй том соён гэгээрүүлэгч, ямархан эрдмийн зиндаатай, ямархан арвин бүтээлтэй, юу гээчийг хийж бүтээсэн байхыг хэн мэдлээ. Ид хий нь арилж, шөрмөс нь чангардаг 35-хан насандаа зүйрлэшгүй ихийг амжуулж бүтээсэн юм. Ингэхлээр хэлмэгдэл хэлмэгдлийн дотроос оюун санааны авьяас билгийг тасалдуулсан хэлмэгдэл юугаар ч нөхөхийн аргагүй.

Хувь хүний амьдралын хувьд ч сайхан гэр бүлийг үүсгэж, сэтгэл дүүрэн жаргалтай амьдарч гал голомт залгамжлах үр хүүхэд үлдээсэнгүй. Сүүлийн явалтаар Буриадаас ирээд хаа газрын ч юм, нэгэн татар Жена гэгч хүүхэнтэй амьдралаа холбосон нь тэсвэрлэхийн аргагүй хариг хатуу ааштай нэгэн байжээ. Олон нийтийн дааж давшгүй ажилтай түүнийг элдвээр хардаж, хурал хуй хаа байгаа газар нь дайрч ордог, бараг эр хүнтэй явахад хүртэл нь сэжиглэдэг байсан байх юм. Харин түүнээс гарсан Буяннэмэхийн хүүхэд Ленинградд 80 гаруй настай амьд сурагтай. Судалбал сонин байх болов уу? Уур хилэн нь хөдлөхөөрөө аяга тавгаа хагалан, “*Чи төрийн эсэргүүн. Чиний юу хийдгийг, хэнтэй хуйвалддагийг дарга сайд нарт хэлж илчилнэ, чи бол хувьсгалын дайсан, намаас хөөлгөнө, шоронгийн хадаас болгоно, чиний холбоотон хятадын тагнуулын сүлбээтэн Мэрсэй, Буянгэрэл нарыг би мэднэ. Манай талын татар хүн дотоод яамны чухал албанд ажилладаг*” гэхчилэн дайрч давшилж сэтгэл санааны хямрал дээр бүр илүү хямрал үүсгэдэг байв. Тэр аймшгийн татар хүүхэнд бүх мөнгө хөрөнгө, тэтгэвэр тэтгэмжээ өгч арай хийн салжээ. “*Эх орноосоо гадагш оргон гарсан, баруунтны этгээд, эхнэрээ дарлаж, гэр бүл салсан*” гэдэг шалтаг шалтгаанаар намаас хөөхөөр тогтжээ. Буяннэмэх ийм дарамтыг тэсч чадсангүй, өөрийн эрхгүй хэсэг зуур архинд автаж, улмаар цагдаа сэргийлэхэд баригдаад бас гянданд 6 сар сууж дайснуудынхаа бах тавыг хангажээ.

Сүүлд Халтархүү хэмээх намын сургуулийн сурагч боломжийн аятайхан бүсгүйтэй сэтгэлийн холбоотой байсан тухай Чойжилын Чимэд “*Мегаллан хаагуур гарсан бэ*” номондоо дурдсан байдаг. Гэвч “*Оргодол босуул, хэзээ мөдгүй баригдах найдваргүй этгээд, энэ чинь баруунтан учраас дайсан гэсэн үг, чи гон бие гозон толгой болоод үлдэнэ, аягүй бол хамсаатан сүлбээтэн болно*” гэх зэргээр хар буруу санаатнууд янз бүрийн ятгалга хийснээр тэр хүүхэн нутаг руугаа явлаа гээд эргэж ирсэнгүй. Үүнээс хойш түүний хувийн амьдрал ёстой нөгөө хөмөрсөн тогоо мэт мэт хав харанхуй болжээ. Баригдахын өмнө одоогийн “Ард” кино театрын урд хоёр өрөө байранд зээ дүү Ёндонжамцтай хоёулахнаа амьдарч байсан тухай зохиолч Х.Зандраабайдийд ярьсан байдаг. Түгшүүртэй царайтай, хянамгай харцтай,

дотогшоогоо бодлогоширсон тэрбээр шилтэй ягаан шингэн марганцын уусмал байнга дэргэдээ байлгадаг байжээ. Энэ бол хоолны хордлогыг түргэн тайлдаг зүйл юмсанж. Аминд аюул тулгарч байгааг алхам тутамдаа мэдэрч байснаас үүнийг биедээ авч явдаг байсан байна.

Ингээд улс орон даяар хэлмэгдлийн хар шуурга дэгдэж Зөвлөлтийн Батлан хамгаалах ардын комиссарын орлогч Д.И.Смирнов, Дотоодыг хамгаалах ардын комиссарын орлогч М.Ф.Фриновский нарын дарга сайд нар 1937 оны 8 дугаар сарын 8-нд “Заговор № 1” (“Хуйвалдаан -1”) хэмээх даруй дайчлан баривчлах 115 эсэргүүний нэртэй ирэхэд “С.Буяннэмэх уран сайхны зөвлөлийн дарга” гээд 29-д бичигдсэн байна. Түүний амьдралын сүүлчийн мөчийн талаар янз янзын яриа байдаг. Жараад оны үед цагаатгалын комиссыг ахалж байсан Тогоочийн Гэндэн гуайтай ярилцлага хийх завсараа асуухад “Буяннэмэхийг цаазлахаар машин дээр авч явахад жанжсин штабын нэгдүгээр орлогч “барон” хэмээх Дашзэвэстэй сүрхий маргалдахад харгалзагч офицер “Та хоёрын амыг ингээд таглачихья” гээд аманд алчуур чихчихсэн юм билээ. Яг буудуулаагүй, цаазын газар руу хүргүүлэх замдаа бүтээж үхсэн юм билээ” гэсэн. Олон хоног хоригдож ядарч доройтсон, бие муу зохиолч шүдэнзний мод шиг зайгүй чихэж ачсан тэргэнд олны хөлд үрэгдсэн гэж “улаан эрдэмтэн” хэмээх бас нэг эсэргүү хэргээр олон жил шоронд хатаагдсан орчуулагч Бархасын Банзрагч бүр наяд оны эхээр хэлж байсан.

С.Буяннэмэх 1920 оноос амьдралын сүүлчийн жил хүртэлх энэхүү 17 жилийн шинэ монгол улсын төр, нам, урлаг утга зохиол, сэтгүүлзүй, соёл, нийгмийн түүх болгонтой холбоотой, асар их нөлөөтэй явсан ирсэн ардын намын анхны гишүүн, “Үнэн” сонинг анх гаргасан анхны сэтгүүлч, хувьсгалт уран зохиолын анхлан гаргагч, Монголын уран зохиолын анхны онолч, Монголын зохиолчдын байгууллагыг анх үүсгэн байгуулагч гээд анхны гэвэл олон юмны анхдагч болохоор үнэхээрийн олон талтай хосгүй гавьяат хүмүүн мөн.

НЭГЭН УТГА ДАЛДАЛСАН ТУУЖИЙН ТУХАЙД

Шинэ Монголын хамгийн ууган, алдарт зохиолч С.Буяннэмэх амьдралынхаа туршид айдас хүйдэс, ихээхэн зовиур шаналгаатай явсан ч гэлээ уран зохиолын бүх төрлөөр бичиж, хожмынхонд чамгүй сайхан өвийг үлдээжээ. Тэрбээр тухайн үедээ өрнийн болоод дорнын боловсролоор ялгарсан томоохон сэхээтэн байсны хувьд уран бүтээлийн төдийгүй сэтгэлгээний эрэлч хайгуулч байв. Нэгэн цаг үед амьдарч нэгэн цаг үед бүтээл туурвилаа хийж явсан зохиолчдын нэр нөлөө, бүтээл туурвилын жин даац, уран зохиолд байгуулсан гавьяа зүтгэл, хамгийн анхны зохиолыг бичсэн зэргийг тунгаан судлан үзвээс Сономбалжирын Буяннэмэхийг Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч гэж бүрнээ үзэж болохоор байдаг юм. Энэхүү шинэ үеийн уран зохиолыг хэн үндэслэсэн юм бэ?, хэн нь илүү гавьяатай, хэнээс эхлээд ярих ёстой юм бэ? гэдэг асуудал анхаарал татсан зүйлийн нэг мөн. Тэрбээр Д.Нацагдоржоос дөрвөн насаар ах болохоор арай түрүүхэн бүтээлээ эхэлжээ. Үүнийг ард түмний сэтгэлд оршсон хайртай их зохиолч Дашдоржийн Нацагдоржтой сөргөлдүүлэх гэж байгаа хэрэг биш, бодит баримтад тулгуурлавал ингэж үзэхээр үндэслэл байгаа юм. Ингэлээ гээд их зохиолч Д.Нацагдорж ч бүдгэрэхгүй.

С.Буяннэмэхийн зохиол бүтээлийг Д.Нацагдоржийнхтой харьцуулбал урлахуйн эрдэм, зохиолчийн үнэт зүйлс талаасаа ч, утга зохиолын хэлийг шинээр бий болгосон

талаасаа Д.Нацагдорж илүү жин дарах төдийгүй, түүний бүтээл олон түмний сэтгэлд үнэхээр хүртээл болж чаджээ. Харин уран зохиолын онол, судалгаа, шүүмж, сэтгүүлзүйн бичлэг талаасаа төдийгүй улс нийгэмд гүйцэтгэсэн гавъяа зүтгэлээрээ С.Буяннэмэх илүү жин дарах бөгөөд хэн нэгнийг нөгөөгийн эсрэг тавьж, зэрэглэж эрэмбэлэхэд төвөгтэй байж болох ч бас чиг болохгүй гэх газаргүй.

Хоёулаа л уран зохиолын бүх төрлөөр бичсэн аргагүй л нэгэн үеийн хурц тод төлөөлөгчид билээ. Энд нэгэн онцлог бий. Улс төрийн үйл ажиллагааны хувьд С.Буяннэмэх илүү идэвхтэй төдийгүй МАН-ыг байгуулахад бүр анхнаасаа гишүүн болж янз бүрийн ажил алба хашиж явжээ. Энэ нь нөлөөлсөн ч байж магад түүний бүтээл бүрт нь нийгэм, улс төрийн агуулга гүн гүнзгий шингэсэн байдаг. С.Буяннэмэхэд янаг амраг, хайр сэтгэлийн нэг ч шүлэг байхгүй бөгөөд шүлэг бүр нь улс төр иргэнлийг шинжтэй байдаг. С.Буяннэмэх бүтээлээ одоогийн бидний бүрэн хүлээн зөвшөөрсөн реалист бус символизм, абстракционизм зэрэг аргаар бичсэн зохиол бүтээлүүдийг одоо ч албан ёсоор цагаатгаагүй байна. С.Буяннэмэх шинэ үеийн уран зохиолын онолын эцэг бөгөөд рационализмыг эхлэн дэвшүүлж, *“Шүлгийн далд утгын”* онол гаргасныг манай өмнөх үеийн судлаачид шүүмжлэгчид байнга шүүмжилсээр, эрс тэрс байж боломгүй зүйл хэмээн улиглан ухуулсаар ирсэн. Өнөө цаг үед уран сайхны сэтгэлгээ хязгааргүй тул ямар нэгэн аргыг товойлгон тулгаж болохгүй гэсэн онол нэгэнт зөвшөөрөгдсөн ч түүний чөлөөт сэтгэлгээний онолын талаархи буруу зөрүү ойлголтыг залруулаагүй байгаа юм. Ингэж үзвэл, тэрбээр хэлмэгдлийн цаламд өнөө ч амьдарсаар байна. 90-ээд оноос хойш монголын зохиолчдын их хурлууд цөөнгүй болсон ч онолын ийм асуудалд хариу өгөх нь чухал байжээ. Харин Д.Нацагдоржийн зохиол бүтээл бол бүхэлдээ бодит байдалд тулгуурласан реалист зохиолууд хүмүүсийн сэтгэлд илүүтэй хүрч, утгазохиолын шинэ хэллэгийг бий болгосныг түрүү дурдсан. Түүнд эрүүл мэндийн сэдэвт ухуулгын зарим нийгэмдээ үйлчилсэн шүлгийг эс тооцвол урлах эрдмийг бүрэн эзэмшсэн, жинхэнэ авьяас билэг нь гялалзсан, урлаг гоо сайхны жам ёсны зүй тогтолт харилцааг нарийн мэдэрч шингээсэн байдгаараа онцлогтой.

Шинэ үеийн уран зохиолын үүсэл 1921 оны ардын хувьсгалтай маргашгүй холбоотой. Тэгвэл хувьсгал мандахын өмнөхөн С. Буяннэмэх *“Таван мөнгө хүрэхгүйгээр түмэн ардыг худалдсан халхын ноёд”* гэсэн анхны шүлгээ бичиж байсан ч бүрэн эхээрээ уламжлагдаж ирсэнгүй. Ингэснээрээ яах аргагүй шинэ үеийн уран зохиолын анхны шавыг тавьсан төдийгүй, зохиолчдын байгууллагын анхны шавыг тавигч юм. Утгазохиолын анхны хэвлэл *“Уран үгсийн чуулган”*-ыг анх үндэслэсэн байна. Түүнээс хойш дөрвөн жилийн дарга их Д.Нацагдорж *“Бүхий олон багачууд”* хэмээх пионерийн дууг зохиосон нь түүний анхны бүтээл байлаа.

Өгүүллэгийн хувьд *“Их тэнгэрийн дүлий”* нийтлэл сэтгүүлзүйн бүтээлийн хувьд *“Гайхамшигт учрал”*, шүлгүүд нэгэн үед монголын төрийн сүлд дуулал болж байсан *“Монгол интернационал”*, жүжгүүдээс нь *“Харанхуй засаг”*, шүүмж судлалаас *“Утга зохиолын онолын үүд”* бол үеийн үед хэв шинжээ хадгалах сор бүтээл гэж болно. Эцсийн эцэст их Д.Нацагдоржид *“Харанхуй хад”* хэмээх маш сонин сэтгэмжит аль ч талаас нь, яаж ч тайлбарлаж болох, утгыг хэн хүнгүй хүлээн зөвшөөрмөөр мадаггүй тайлахын аргагүй өгүүллэг байдаг бол С.Буяннэмэхэд *“Алсыг зорьсон алтан загас”* хэмээх уран сэтгэмжит зохиол байдаг. Адал явдал, үлгэрийн шинжийг хадгалсан боловч цаанаа утгыг нуун далдалсан улс төрийн ёгтлол бүхий зохиол гэж болно. *“Харанхуй хад”* өгүүллэгийн талаар олон судлаачид, эрдэмтэд өөр өөрсдийн саналаа

сонирхолтойгоор дэвшүүлсэн боловч яг хүлээн зөвөөрөхүйц дүгнэлтэд хүрч очсонгүй. Таамаг л дэвшүүлнэ үү? гэхээс нэгэн тийш болгох ийм боломж ч байхгүй бизээ. Ер нь сонгодог зохиолын ид шид нь олон ургальч бодлын өдөлт сэдэлт байдаг. Энэхүү олон санаа бодол нь “Д.Нацагдорж судлал” - ыг улам гүнзгийрүүлж, уран сайхны танин мэдэхүйн сэтгэлгээг нарийсгаж, далдыг нээх эрэл хайгуул хийж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой.

Энэхүү “Алсыг зорьсон алтан загас” тууж нь чухамхуу далд утгаар бичигдсэн тул чухам юуг яаж харуулсан бэ? гэдэг утга учрыг тайлахад бэрхшээлтэй зохиол юм. Социалист реализмын үеийн утгазохиолын шүүмж, судлалд энэхүү туужийн талаар бичихээс зайлсхийж, огт дурсдаггүй байсан нь өнөөгийн цаг үе нийгэмд таарахгүй тэрс эсэргүү агуулгатай зохиол гэж үзэж байсантай холбоотой ажээ. 1968 онд Хэл зохиолын хүрээлэнгээс гаргасан “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх” номонд С.Буяннэмэхийн бүх хүүрнэл зохиолын талаар судалгааны шинжтэй тайлбар өгсөн атлаа ганц “Алсыг зорьсон алтан загас” туужийн талаар нэг ч үг өгүүлбэр байдаггүй нь нэгд, зөвлөлтийн эсрэг харш үзэл санаатай зохиол гэсэн байж болох хоёрт, реалист бус аргаар бичсэн гэж үзсэнтэй холбоотой нь мэдээж. Бүр сүүлд Боловсролын их сургуулийн эрдэмтэн багш нар, судлаачдын гаргасан “Утга зохиолын шинжлэл” хэмээх буурьтай номд “Туужийн төрөл зүйлийн төлөвшил, хөгжил” хэмээх бүлэгт зөвхөн “Малчин Товуудайг” дурдсан байдаг. Энэ тууж нь төдий л сонирхол татахаар зохиол биш боловч хал балгүйгээр нь гагц түүнийг л тойрч ярилцсан байдаг.

Харин “Алсыг зорьсон алтан загас” тууж нь уран сэтгэмж болоод утга санааны хувьд Д.Нацагдоржийн “Харанхуй хадтай” дүйцэх зохиол боловч энэ тухайд задалж дүгнэлт төдий л өгөхгүй иржээ. Харин манай утга зохиолын онолч, нэрт судлаач Д.Галбаатарын магадлан тайлал ихээхэн сонирхолтой юм. Тэрбээр “Монголын хувьсгалчид анхлан очсон үеийг зохиолч оорийн далд утгын онолоор гарган бичсэн бололтой” гэсэн таамаглал дэвшүүлжээ. “Зам зуур таарч айлгах загасчин, мөсөн далайн хавнууд, амаа ангайлгаж шүдээ ярзайлгасан аймшигт амьтан хуурай газрын иуламнуудын дүр нь эсер, меншевик, анархист зэрэг зөвлөлт засгийн дайснуудын ёгт билгэдэл болох нь тодорхой болно”¹ хэмээн учгийг тайлах герменевтикийн мэдрэмжээр утгыг тайлжээ. Энэ бол утга зохиол судлалд уг туужийн далд санааг тайлж бичсэн анхны санаа сэдэл юм. Яг үүнийг үгүйсгэх аргагүй, тийм байж болно, үгүй ч байж болно.

Харин миний хувьд дараах зургаан үндэслэлийг онцолж тодруулахыг хичээлээ.

Нэгд: Энэ зохиол төрөл зүйлийн хувьд өнөөгийн түвшинд “тууж” гэхэд эргэлзээтэй. Ердийн л өгүүллэг юм. Тэр үед “яруу найраг” гэсэн ч нэр томъёо орж ирээгүй байсан. Хүүрнэл зохиолыг гагц тууж гэж эрт дээр үеэс ярьж байсан нь “Чойжид дагинын тууж” “Эр хоёр загалын тууж” гэх зэргээс илэрхий. Зохиолч өөрөө туужийг хэрхэн ойлгодог байсан бэ? гэвэл “...Тууж хэмээгч нь их төлөв үнэн зүйлийг бичих ба тууж намтрын утга чанар нь их л ойролцоо мэт” гэсэн байх юм.

Хоёрт: Цаанаа улстөрийн ноцтой санаа агуулж байгаа учраас далд утгаар үлгэрийн хэлбэрээр бичсэн монгол шинэ үеийн уран зохиолын анхны “улстөрийн зохиол” гэх гээд байгаа юм.

¹ Д.Галбаатар “Монголын уран зохиолын онол түүхийн зангилаа асуудлууд” 365-366-р тал.,

Гуравт: Зохиолын санаа, агуулгыг наашаагаа аймшигт гучаад оны дэвсгэр рүү татаж авчрах гээд байгаагаараа утга зохиол шинжээч Д.Галбаатарынхаас арай өөр өнцгөөс харах гээд байгаагаагаа хэлэх хэрэгтэй. Яагаад вэ? гэвэл 20-иод оны үйл явдлыг утга далдалж бичих шаардлагагүй төдийгүй харин ч бүр ил тодоор тодорхой бичих нь өөрт болоод улс оронд хэрэгтэй зүйл юм.

Дөрөвт: Коминтерн болоод улааны үзлийн аюулыг зүрх сэтгэлээрээ мэдэрсэн түүний намтрын нуугдмал далд байдал нэгэнт хангалттай байгааг өмнө дурдсан тул хэзээ мөдгүй угтан ирэх аюулт хэлмэгдлийн шуургыг зохиолчийн зөн билгэдлээр эхэлж үнэрлэж мэдэрсэн зохиол гэх гээд байгаа юм.

Тавд: “Алсыг зорьсон алтан загас”-ыг чухам хэдэн онд бичсэн, хэвлэгдсэн эсэх нь мэдэгдэхгүй байгаа. Энэ мэтийн даацтай, оюунлаг, хийсвэрлэл орсон зохиолыг нэлээд юм үзэж, бяр бяд суусан хойноо гучаад онд бичсэн байж таарна. Ер нь Д.Нацагдорж, С.Буяннэмэх аль алин нь сургууль соёл, албан ажил, хувьсгалын хэрэг гээд зүсэн зүйлийн юманд дарагдаад гучаад оноос л гол бүтээлүүдээ бичиж туурвисан байдаг. Тэгээд гучаад онд манай толгой сэхээтнүүд “улааны үзэл”, “коммунизм”-ыг ил далд эсэргүүцэн монгол маань яагаад биеэ дааж болдоггүй юм бэ? гэх элдэв хэл яриа шургадаг, орос сургагч нарын дураар авирлагчдыг эсэргүүцдэг байсан түүхтэй.

Зургаа: Харийн орныг хөл алдан дагаад, түүнээс илүү ихийг хүсээд, найдвар бага байна. Чухамдаа өөрийн эх орон шиг сайн сайхан зүйл алга. Биеэ дааж тусгаар хөгжих нь зүйтэй гэсэн санаа зохиолын сүүлд бүр хурц илэрчээ. Түүний 1934 оны гуравдугаар сарын 10-нд МАХН-ын Төв хороонд бичсэн захидалдаа “...Зүүний хэтэрхий хувьсгалчид дэмий ангалзан цаашид зөвөөр засаад явуулах хэргээ харин хэтрүүлж энэ өдөр СССР-ийн мэт гайхамшиг их нийгэм журамт улс болох хэмээн хаширалдаж эргүүлж засах байдлыг алдагдуулахаар үл барам сэргээж ирсэн ядуу дунд ардын нүүдлийн аж амьдарлага ба үйлдвэрийн идэвх оролдлогыг харин хэрүүл тэмцлийн замаар оруулан бүр ч хоосон ядуу болгохын чанартай лоозон тавих зэргээр бузарлаж орхисон болно...” гэж өөрийн үзэл бодлоо маш хурц тодоор тулган тавьсан байх юм. Бас түүнийг дотоод яаманд матсан Н.Гомбожав гэгчийн мэдээлэлд “...Тэрбээр Сталиныг муугаар хэлж, Лениний зарим суртлыг би зөвшөөрдөггүй, монгол улс зөвхөн хойт хаалгаа нээж бусад хаалгаа хаажээ. Харин үүний эсрэг байх хэрэгтэй гэх мэтийн хувьсгалын эсрэг бодол санааг илэрхийлж байв” гэж бичсэн байх юм. Энэхүү санаагаа тэр чигээр нь “Алсыг зорьсон алтан загасад” багтаасан мэт санагдаж байна. Хэтэрхий нэгэн их гүрнийг шүтэж, өөрийн байдал үндэсний онцлогоо орхисон гэдгийг сануулсан, болгоомжлуулсан, сэрэмжлүүлсэн, учрах аюулыг нэгд нэггүй нээж харуулсан зохиол биш гэж үү? С. Буяннэмэх оросын юм бүхнийг шүтэгч биш, өөрийн нүдээр харагч, өөрийн сэтгэлээр тунгаагч гэдэг нь нэг бус зүйл дээр ажиглагддаг. Түүний “Өчүүхэн тэмдэглэл” хэмээх дурсамжийн өгүүлэлд бүр 20 нас ч хүрээгүй тэрбээр анх хойш хил гаран Эрхүү орох галт тэргийг үзээд сонин хачныг гайхсан мөртлөө “...Энэ байшинтай тэргэндээ даанч цонх хийхгүй яасан ухаан муутай хүмүүс вэ? гэж гэмшиж улаан вагонд суугаад хойш явсан бөлгөө” гэжээ.

Тухайн үед С.Буяннэмэхийн намтар, зохиол бүтээлийг нийтлэх ажлыг хийхэд тухайн үеийн Нийгмийг аюулаас хамгаалах яамны орлогч сайд Р.Гүнсэн дэмжсэн ч гэлээ “Тэдний бүтээлийг хэвлэж нийтийн хүртээл болгох нь буяны үйлс юм даа. Тэгэхдээ үзэл суртлын талаар харин юм бий байх. Хянуур хандаарай” гэсэн хэмээн судлаач Г. Дуйнхаржавт сануулж байжээ. Наяад оны дундуур миний бие өгүүллэг судалдаг нэгэн шаггүй шүүмжлэгчээс тэр “Алсыг зорьсон алтан загас” зохиол ямар

утга учиртай, ямар агуулгатай зохиол вэ? Та юу гэж боддог вэ? гэхэд *“Аа мэдэхгүй, бидний л ах дүү зөвлөлт рүү орох бүх зам дагуух газрын марирут дүрслэгдсэн байдаг шүү дээ. Буудал болгон, хот болгон дээр махчин араатан мэт дайснууд тааралддаг биз дээ. Тэгэхлээр “антисоветизмд л” хамаарах зохиол байх. Буяннэмэх ч эсэргүү нь эсэргүү байсан бололтой”* гэж нэлээд цэрвэсэн байдалтай хэлж билээ. Ийм сэрэмжлүүлэг, үзэл суртлын айдас сүүдэр мэт үргэлж дагаж явжээ. Иймээс л манай нэртэй судлаачид, шүүмжлэгчид энэ туужийн талаар алив хурц дүгнэлт хийхээс зайлсхийж ирсэн бололтой. Үүн дээр утга зохиолын арга барилын *“далд утга”* гэгчийг үзэн ядаж байсантай холбоотой нь мэдээж. Энэ мэт нь миний сонирхлыг аль хэдийнээс татсаар байсан боловч хүмүүстэй ярилцахад эл зохиолыг үнэндээ бараг нь уншиж үзээгүй нь тодорхой болсон юм. 1962 оны арваннэгдүгээр сарын 16 нд БНМАУ-ын Дээд шүүхийн бүгд хурлын 017 дугаар тогтоолоор цагаатгасан юм. 1963 оны намын үзэл суртлын ажилтны анхдугаар зөвлөлгөөнөөс С.Буяннэмэхийг улс төрийн талаар цагаатгасан ч *“Уран бүтээлийг нь алдаа дутагдалтай”* гэж тэмдэглэж байлаа. Тэрхүү учир дутагдалтай эсэргүү зохиолын нэг нь энэхүү *“Алсыг зорьсон алтан загас”* орж сэжиглэгдсэн байж таарна. Утгыг далдалж үлгэр домог шиг гэм халгүй юм шиг бичсэний ухаанаар хожмынхон *“саваагүй хоёр загасны үлгэр л байна”* гээд хэвлэлчихсэн ч байж магад. Гэвч хамгийн ноцтой агуулга бүхий улс төрийн зохиол байсныг анзаарсангүй.

С.Буяннэмэх хэрэг дээрээ *“далд утгат шүлэг”* гэдгийг манай утга зохиолын онолд анх гаргаж ирсэн хүн. Тэрбээр далд утгаа хэрхэн тайлбарласан нь сонирхолтой. *“Далд утга гэгч утгыг мэдэхгүй гагцхүү бодсоны хойно сая тайлбарлаж мэдэх болой. Энэ зүйлийн шүлгүүд бодлоготой бөгөөд энэхүү тайлбарлах шүлэг нь ч мөн бодлогыг нээгдүүлэх буюу эрдэм оюуныг шалгахад тустай”* гэжээ. Гучаад онд далд утгатай шүлэг бичих түүнийгээ тайлбарлах утгыг нээх нь тун түгээмэл байсан бөгөөд урлал, сэтгэмж сэтгэлгээний сонирхолтой эрэл хайгуулын нэг байжээ. Дэндүү ил цагаан, зөвхөн толгой холбосон үгийн хэлхээс бүхий гэнэн шүлгээс гарах гарцыг хайж байсан эрмэлзэл бололтой. Бас онол эрдмээр түүчээлж явсан сэхээтний хувиар гучаад онд натурализм газар аван маш хүчтэй дэлгэрэхийн эсрэг энэхүү далд утга бөгөөд өнөөгийн реалист бус хийсвэр сэтгэлгээг сөргүүлэн гаргажээ. Үүнийг тухайн үедээ мэдрэх сөхөөгүй байжээ. Энэ бол оюун санааны, онолын маш хүчтэй хөгжил дэвшил байлаа. Мөн тэрээр бичихдээ *“Фантазия гэдэг хий зохиол бол үнэхээр их сонирхолтой байдаг бөгөөд чухамхуу байгаагүй ба байж болигүй мэт зүйлийг байж болохоор зохиож чаддаг нь үнэхээр урьдын хүний авхаалж ухааны шим чадал нь байсныг мэдвэл зохионо”* гэж бичснээс үзэхэд *“Алсыг зорьсон алтан загасыг”* бичихдээ таамаг төдий хандаагүй асар их ул үндэстэй, юмаа төгс мэддэг онолчийн хувьд дэвшүүлэн тавьсан нь тодорхой байна. *“Бодлоготой байх”* гээд өөрийн зохиолыг өөрөө тайлчихжээ. Тэрхүү бодлого нь орос орныг элдэвчлээгүй харин дээрэнгүй харгис үзэл бодолтой хүмүүсийг л шүүмжилсэн юм.

С.Буяннэмэх далд утга, фантазия буюу хийсвэрлэх, уран сайхны чөлөөт сэтгэлгээг шүтэх хандлагатай байсан нь түүний *“Алсыг зорьсон алтан загас”* туужтай шууд холбоотой гэдгийг хэн ч үгүйсгэсэнгүй. Харин үүнийг хэрхэн тайлбарлах нь тодорхой бус. Цаашдаа манайхан оюун ухаанаа уралдуулж бишгүй эрдэм судалгааны өгүүлэл гаргах бизээ. Академич Х.Сампилдэндэв *““Алсыг зорьсон алтан загасны үлгэр” өгүүллэгээ үлгэрийн хэлбэрээр ёгт утга санаатай бичиж, гадаад далайд аялсан*

хоёр загасанд тохиолдсон адал сонин үйл явдлын дүрслэлээр эрмийн далайд аялахын гайхамшигийг өгүүлсэн байдаг” гээд орхижээ. Ёгт гэдэг санаагаа тайлбарласангүй. Загасыг ёгтлох ямар үндэс байна вэ? Тэгвэл юуг ёгтолсон байж таарах вэ? гээд бодвол нэлээд гаргалгаа гаргаж болохоор байна. Тэгэхлээр хүч тэнцвэргүй том жижиг орны тэнцүү биш харилцааг л ёгтолсон болж таарах гээд байгаа юм. Өөрийн гэсэн толгойгүй бол, өөрийн гэсэн соёлгүй, өөрийн гэсэн боловсролгүй, өөрийн гэсэн ухаангүй бол зөвлөлт хэмээх аварга загасны хоол болох юм байна шүү гэдгийг л ёгтлон харуулжээ гэх үндэс байна.

Цөл, Гил хэмээх энэ хоёр загас бол ерийн нэг домог, үлгэрийн загас биш, ер бусын гадаад улстөрийн адармаат нөхцөлийн дундах амьдралыг тайлах зориудын зорилготой бичигдсэн зөн билгэдэл, ёр совин, учиг урхаг, таамаг санаа, сэдэл, дотоод төрөгдөл, дүрийн субьектив шийдэл бүхий символизмын чиглэл бүхий зохиол ажээ гэж үзэж байна.

Цөл, Гил гэгч хоёр загас гол мөрөн, далайн усаар аялж байгаа боловч үнэхээр л түрүүчийн нэгэн шүүмжлэгчийн хэлснээр Зөвлөлт - Орос орон руу одох орох зам газрын зураг тэр чигээрээ яг таацах ажээ. Д.Нацагдорж 1926 онд *“Улаанбаатараас Берлин хүртэл”* шүлгээ өртөө буудлын газрыг хүртэл тун бодитой нүдэнд харагдтал өгүүлсэн нь тайлахад бэрх бус. Монголын хоёр ууган зохиолч огторгуйд од мөргөлдөх мэт нэгэн цэгт ийнхүү мөргөлджээ. Аян замын сонин явдалт гэж болох зохиол нь хоёулаа алс газар эрдэм сурахаар явж байгааг харуулдаг. Үүнээс Д.Нацагдоржийн реалист арга, С.Буяннэмэхийн реалист бус арга өдөр шөнө мэт тод ялгарч байна. Модернист утга зохиолын талаар ямар чүг яриагүй байх үе буюу 1968 онд Д.Намдаг *“С.Буяннэмэхийн “Үнэн” гэдэг жүжиг символ хэмээх утга санаанд зөн билгээдлийн үүднээс бичигджээ”* гэж байв. Тиймээс реалист бус аргыг санамсаргүй биш, бүр онолын үүднээс үзэж, утга зохиолын нэгэн чухал арга гэж үзээд, онол практикийг туршсан анхны зохиолч юм. иймэрхүү сонин, уран хийсвэр сэтгэлгээний аргаар бичигдсэн *“Шоргоолжийн тивд зугаацсан нь”* шүлэг бичсэн нь хэвлэгдэж бидэнд хараахан ирээгүй байна.

Улс төрийн агуулга бүхий адармаатай энэхүү зохиол нь хойноос элдэв тусламж гуйхаар яваагүй, зохиолд өгүүлснээр *“...Энэхүү ертөнцийн дээр гадаад их далайн орон байдаг гэсэн. ...Тэр оронд нэгэнт очиж гайхамшигт байр байдлыг нь үзэж ирвэл ...манай бага орны олон аймаг, далайн эрдмээс олох нь юуны магад”* гэж Цөл ятгаж байна. Энэ нь хувьсгал ялаад гадаадад явж эрдэм суралцах тухай ярьж эхэлсэн түүхэн үйл явдлын онц цагийн ялгааг тодруулж байна. Гэтэл нөгөө гайхамшигт орон (*Орос До.Ц*) гэгдэх нь тамын орон төдийгүй, амь өрсөн арайхийж аюулаас мултарч үхэж үрэгдэхийн даваан дээр эх орондоо буцан ирж байгааг дүрсэлжээ. Өөрөөр тааралдаж байгаа загаснуудын ааш араншин, газар орны байдал, хатуу харгис чанар нь коминтернийн болоод шинэ зөвлөлийн орны удирдах хүмүүсийн зан араншин тул аварга загасад идүүлэхгүй биеэ даах, хомрогolon хэлмэгдүүлэх талаар юу ч хийж болох аюулыг урьдчилан мэдэрч, байдал төрхийг ойлгуулах гэсэн утгатай мэт байгаа нь илт бус уу? Учир нь С.Буяннэмэх залуугаасаа Зөвлөлийн оронд гурван удаа ч явж улстөрийн байдлыг танадаж мэдсэн цаашид яахыг ч зөнгөөрөө мэдэрсэн, хэзээ нэгэн цагт монгол минь ийм л дарангуйллын дагуул орон болно гэж шаналсан жинхэнэ ясны зохиолчийн шаналал, зөн билэг, таамаг танадалт юм. Шинэ хөрш орон, анд нөхдийн байр байдлыг шуудхан хэлж болохгүй учраас үлгэр хэлбэрээр сэхээлиг хүмүүст хүргэн таниулан мэдүүлэх зорилгоор бүтээсэн болов уу? гэхээр байгаа юм.

Цөл, Гил хоёр урдын бодсон гайхамшигт сайхан зүйл нэгээхэн ч үгүй дан гамшиг, аймшиг, зовлон бэрхшээл дайсан мэттэй үе үе тулгардаг. Ангар мөрөнд ороод ирэхэд, *“Эдний орон гэгч юутай аймшигтай, юутай зовлонтой орон бэ? Манай газар бол энэ мэтийн аюул зовлон огт үгүй бөгөөд нэг насандаа жарган цэнгэн явах нь юутай гайхамшигтай орон бэ? Юунд тийм орноосоо гарч хол бэрх замыг хөөвөө”* гэж гэмшиж байгаа нь энэ их Орос гүрнийг хэлмэгдүүллийн аймшигт харгис хэрцгий орон болж хувираад үүнийг дагаад хэлмэгдэл, сүйрэлийн аюултай орчилд орж болохыг урьдчилан сануулсан хэрэг мөн.

Хэлмэгдлийн гай зовлонг амьдралын туршид өөрийн биеэр амссан С.Буяннэмэхийн хувьд ингэж хэлэхээс өөр яахав. Элбэгдорж Ринчиновоос эхлээд цөөнгүй холын иргэн буюу аварга загасын аманд орж явсан түүний сэтгэл дундаас сайн сайхан юм ундрэн гарах аргагүй байв. Гадаад далайн загаснуудын ховдог идэмхий, муухай авир араншин, ховдог шунахайг харуулсан нь мөнөөх аймшигт хэлмэгдлийн цалам монголчуудыг урхидах цаг ойртсоныг зөн совингоороо мэдэрч, айхтар сэтгэл түгшин бэлгэдэж бичсэн байх магадлалтай. Зохиолын төгсгөлд нөгөөх агуу их зорилготой явсан хоёр загасанд аюул тохиолдож далайн аварга том загас амаа ангайн цахилгаан мэт нүдээ бүлтийлгэн ар шилээсээ арван алд урт ус цоргиулан годгодуулж үнэхээр аймшигт зүйл тохиолдож байх юм. Цөл, Гил хоёр арайхийн амьд мэнд гартал далайн усыг эгшин зуур огторгуй тултал сорон дээшээ аваачин шидэлж байна. Ингээд гэнэт доош буухад уугуул нутагт Орхон улмаар Туул голдоо ирээд туйлын их баясаж байх юм. Энэ нь Цөл хэмээх халх загасыг эх орон нь хүлээн авч байгаа нь тэр аж. Харин Гил нь үрэгдэж алга болжээ. Энэ зохиолыг юуг зөгнөж бичээ вэ? Хэдий үеийн амьдрал вэ? Энэ зохиолоо хэдий үед бичээ вэ? Агуу их хань болох Орос орон гэгчийн тухайд гэрэлтэй сайхныг бичих ёстой ийм үзэл бодолтой хүмүүн яагаад үүнийг ёрлож бичээ вэ? Зохиолчийн зөн бэлэг гэдэг нь энэ үү? гэсэн асуудлууд хойно хойноосоо цувран гарна. Загасанд тохиолдсон адал явдал бол хүмүүс болоод манай орны хувьд тохиолдох аюул заналыг далд утгаар харуулсан хэрэг дээрээ үлгэрийн ч биш, үзэл санааны хувьд улстөрийн, хэлбэр агуулгын хувьд хийсвэрлэл, уран сэтгэмжийн, байр суурийн хувьд үзэл суртлаас ангид, анхны бие даасан, хараат бус чөлөөт сэтгэлгээний зохиол болох нь тодорхой гэж дүгнэж байна.

Харин Туул голд эхэлж таарсан Гил нь гэгч загас нь юу болох вэ? гэдэг нь бас сонирхол татна. Яагаад тэр олон загас дундаас Гил гэгч загасан нөхөр тааралдав? гээд ургуулан төсөөлөх хэрэгтэй. Гил нь магад ч үгүй өвөрлөгч түмнийг төлөөлсөн төлөөлөгч ч байж болох юм. Ар монгол, өвөр монголын нөхөд нийлээд Орос орон руу тусламж эрэхээр аль 1911 –ээд оноос л хамт явцгаасан, хүсдэг юм нь энэ хоёр монголын нэгтгэж нэгэн их Монгол улс байгуулахын төлөө ярьж, тэмцэж байсныг түүх харуулдаг. Гил цуг явж байгаад хачирхалтайгаар гэнэт алга болсон нь ахан дүү Өвөр монголын хувь заяанд орос орон ямархуу нөлөөтэй вэ? гэдгийг харуулсан байж болох юм гэсэн таамаглалыг дэвшүүлж байгаа юм. Ийнхүү Буяннэмэхийн амьдралын туршид туулсан хүнд бэрх далд амьдрал юугаа эргэцүүлэн, Өвөр монгол, Эрхүүд амьдарсан он жилүүд түүнээс төрсөн сэтгэгдэл, төрөгдөлдөө тулгуурлан зөнч оюун ухаанаар, бодол санаагаа нууц далд утгаар *“Алсыг зорьсон алтан загас”* зохиолоо бичжээ гэж үзэхээр байна.

НОМ ЗҮЙ

1. Буяннэмэх С. (1968) *Түүвэр зохиол*. Улаанбаатар.,
2. Монгол Ардын намын гуравдугаар их хурал. (1966) Улаанбаатар.,
3. Галбаатар Д. (2001) *Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд*. Улаанбаатар.,
4. МУБИС, Утга зохиолын тэнхим. (1966). *Утга зохиол шинжлэл*. Улаанбаатар.,
5. Намдаг Д. (1988). *Шинэ Монголын шинэ театр*. Улаанбаатар.,

SUMMARY

The author studies the works of S.Buyannemekh, a contemporary Mongolian writer, whose distinctive composing style was about describing the secret and hidden lives of people. A novel named 'Golden Fish Traveling Afar', which has a hidden meaning, has been analyzed in this paper.